

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 20/1

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдаанаар мөнгөний бодлогын хүү, төгрөгийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээ, бодлогын хүүний коридорыг өөрчлөх эсэх талаар хэлэлцлээ.

МБХ-ны хуралдаанд макро эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн төлөв, санхүүгийн зах зээл, гадаад, дотоод орчны тодорхой бус байдалд гарч буй гол өөрчлөлтүүд, Ковид-19 вирусын тархалттай холбоотой эдийн засагт үүсч болзошгүй эрсдэлийн талаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцууллаа.

Ковид-19 вирус нь Монгол Улсын эдийн засагт нэг талаас гадаад орчны буюу экспортын бүтээгдэхүүний үнэ, гадаад эрэлтээр, нөгөө талаас Ковид-19 вирусын тархалтаас урьдчилан сэргийлэх хүрээнд хэрэгжүүлж буй дотоод арга хэмжээгээр дамжин нөлөөлж байна. Тодруулбал, Ковид-19 вирустай холбоотойгоор БНХАУ-ын эдийн засаг удааширсан нь манай улсын гадаад эрэлт, түүхий эдийн үнэ, гадаад худалдаанд сөргөөр нөлөөлнө. Түүнчлэн түүхий эдийн экспорт буурах нь уул уурхай, тээврийн салбарын үйлдвэрлэлийг сааруулахын зэрэгцээ төсвийн орлогыг бууруулах эрсдэлтэй байна. Харин дотоод орчинд хэрэгжүүлж буй хилийн хориг болон бусад хорио цээрийн дэглэм нь гадаад худалдааг удаашруулах, эдийн засгийн голлох салбарууд болох уул уурхай, худалдаа, үйлчилгээ, тээвэр болон боловсруулах салбарын идэвхжилийг сааруулах нөлөөтэйг танилцууллаа.

Инфляци 2019 оны 4 дүгээр улиралд төсөөллөөс бага гарахад мах, дотоодын барааны үнийн өсөлт хүлээлтээс бага байсан нь нөлөөлөв. Харин энэ оны 1 дүгээр сард инфляцийн түвшин улсын хэмжээнд 5.6 хувьд байгаа бөгөөд цаашид өмнөх төсөөллөөс нам түвшинд хүрэх төлөвтэй байгааг танилцууллаа. Тодруулбал, Ковид-19 вирусын нөлөөгөөр дотоод эдийн засгийн идэвхжил саарч, эрэлтийн шалтгаантай үнийн өсөлт саарах хүлээлттэй байна. Улмаар инфляцийн түвшин 2020 онд Монголбанкны зорилтот түвшин (8%)-ий орчимд тогтворжих төлөв хэвээр байна.

Эдийн засаг 2019 онд 5.1 хувиар өссөн бөгөөд энэ нь хүлээлтээс бага байсныг онцоллоо. Үүнд уул уурхайн салбарын өсөлт оны сүүлийн хагаст саарч, 2019 онд -0.5 хувьд хүрсэн нь нөлөөлсөн байна. Харин уул уурхайн бус салбар 6.7 хувиар өсөв. Эрэлт талаас хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлт нийт эдийн засгийн өсөлтийг тэтгэж байсан бол импортын сөрөг нөлөө өндөр байв. Цаашид эдийн засгийн өсөлт саарах төсөөлөлтэй байгаа бөгөөд үүнд Ковид-19 вирусын тархалттай холбоотойгоор гадаад эрэлтийн төлөв муудах, түүхий эдийн үнэ буурах зэрэг нь голлон нөлөөлж байна. Харин төсвийн бодлогын төлөв зөөлөрч, тэтгэврийн зээлийг тэглэсэн болон хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа нь эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх нөлөөтэйг танилцуулав.

Батлагдсан төсвийн зардал 2019 оноос 24.1 хувиар буюу 2.4 их наяд орчим төгрөгөөр нэмэгдэхээр байна. Харин Ковид-19 вирустай холбоотойгоор экспортын орлого, эдийн засгийн идэвхжил саарч төсвийн орлого батлагдсан дүнгээс дутаж, төсвийн алдагдал нэмэгдэх эрсдэл байгааг онцоллоо.

Банкуудын зээлийн өсөлт буурч байгаа нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч байна. Зээлийн төрлөөр нь авч үзвэл хэрэглээний зээл өмнөх оноос 8 орчим хувиар хумигдсан бол бизнесийн зээл 11 хувийн өсөлттэй байв. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2020 оны 1 дүгээр сарын байдлаар 15 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй ойролцоо байна. Харин банкуудын эх үүсвэрийн долларжилт сүүлийн улирлуудад нэмэгдэж байгааг танилцуулав.

Өмнөх бодлогын шийдвэрээс хойш гадаад орчинд гарсан гол сөрөг өөрчлөлт нь БНХАУ-д Ковид-19 вирус дэгдэн, бусад бүс нутагт тархаад буйг онцлов. Ковид-19 вирусын тархалтын цар хүрээ, үргэлжлэх хугацаа, түүний эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ өдрөөс өдөрт өөрчлөгдөж байгаа нь манай худалдааны түнш улсуудын эдийн засгийн өсөлт, цаашлаад манай улсын гадаад эрэлт, гадаад худалдааны төлөвийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна.

Төлбөрийн тэнцэл 2019 онд 453 сая ам.долларын ашигтай гарсан бол 2020 онд өмнөх төсөөллөөс муудаж төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэхээр байгааг танилцуулав. Төлбөрийн тэнцлийн алдагдал өмнөх төсөөллөөс нэмэгдэхэд манай улсын гадаад эрэлт, экспортын гол түүхий эдийн үнэ буурах, Ковид-19 вирусын дэгдэлттэй холбоотойгоор нүүрс, газрын тос, төмрийн хүдрийн экспорт буурах, гадаад бондын эргэн төлөлт зэрэг нь голлон нөлөөлөхөөр байна. Харин Оюу-толгойн далд уурхайн хөрөнгө оруулалт, газрын тос боловсруулах үйлдвэрлэлийн гадаад санхүүжилт, дэлхийн зах зээл дээр газрын

тосны үнэ буурах, хэрэглээний импорт буурах, алтны экспортын орлого нэмэгдэх зэрэг нь төлбөрийн тэнцлийн төсөөлөлд эерэг нөлөөтэйг дурдав.

Танилцуулгын төгсгөлд Ковид-19 вирусын тархалт цаашид ямар хугацаанд үргэлжлэх, тархах цар хүрээ болон түүний эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ өдрөөс өдөрт өөрчлөгдөж байгаа зэрэг нь төсөөллийн тодорхой бус байдлын гол эх сурвалж болж байгаа хэдий ч одоогийн боломжит мэдээлэл дээр үндэслэн 2 хувилбар төсөөллөөр нөлөөллийг тооцож, бодлогын шинжилгээнд ашигласныг тайлбарлав.

Мөнгөний бодлогын газрын зүгээс бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулж 10.5 хувьд хүргэх, ЗБН-ийн хувь хэмжээг төгрөгийн эх үүсвэрийн хувьд 2 нэгж хувиар бууруулж 8.5 хувь болгох, мөнгөний бодлогын хүүгийн коридорыг Монголбанкны бодлогын хүүгийн хувь хэмжээнээс +1, -2 нэгж хувийн өргөнтэй буюу тэгш бус хэмтэйгээр шинэчлэх багц бодлогын санал гаргасныг МБХ-ны гишүүд хэлэлцлээ.

Эдийн засгийн идэвхжил суларч, инфляци тогтвортой байгааг харгалзан үзээд энэ удаад бодлогын хүүг бууруулж, зээлийн нийлүүлэлт болон эдийн засгийн өсөлтийг тэтгэх саналыг гишүүд дэмжиж бодлогын хүүг хэдэн нэгж хувиар буулгах талаар хэлэлцүүлэг өрнөв.

МБХ-ний зарим гишүүдийн хувьд эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал болон ирээдүйн төлөвт үндэслэн эдийн засгийн идэвхжлийг дэмжих, зах зээлд дохио өгөх шаардлагатай байгаатай санал нэгдэж МБГ-аас дэвшүүлсэн бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулан, 10.5 хувьд хүргэх саналыг дэмжив. Харин бусад гишүүдийн зүгээс инфляцийн хувьд дарамт харьцангуй бага байгаа үед мөнгөний бодлогын төлөвийг илүү зөөлрүүлэн бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бус 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэн эдийн засгийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүллээ.

Хэлэлцүүлгийн дараагийн хэсэгт банкны системийн ЗБН-ийн хувь хэмжээг төгрөгийн эх үүсвэрийн хувьд бууруулж банкуудын чөлөөт эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар хэлэлцсэн бөгөөд энэ нь зээлийн хүүг бууруулах, санхүүгийн зуучлалыг дэмжих нөлөөтэйг онцлов. МБХ-ны зарим гишүүд МБГ-аас дэвшүүлсэн төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд тогтоох саналыг дэмжлээ. Мөн зарим гишүүд бусад бодлогын шийдвэрийг харгалзан үзэж бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах шийдвэр гаргах тохиолдолд төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээг 1.5 нэгж хувиар бууруулах санал дэвшүүлсэн. Хэрэв ЗБН-ийн хувийг 2 нэгж хувиар

бууруулсан тохиолдолд бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулах хувилбар саналыг гаргаж байсан юм.

Хэлэлцүүлгийн төгсгөлд бодлогын хүүний коридорыг нарийсгах эсэхийг хэлэлцлээ. Хүүний коридорыг нарийсгах нь арилжааны банкуудын Төв банкнаас авах богино хугацаат санхүүжилтийн зардлыг бууруулах нөлөөтэйг онцлов. Энэ нь бусад бодлогын шийдвэрүүдтэй нийцтэйгээр зээлийн нийлүүлэлт болон санхүүгийн зуучлалыг дэмжих зорилготой байна. МБХ-ны зарим гишүүдийн зүгээс бодлогын хүүгийн коридорыг Монголбанкны бодлогын хүүгийн хувь хэмжээнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгож өөрчлөх буюу коридорыг нарийсгахын зэрэгцээ тэгш хэмтэй байдлыг хадгалах санал дэвшүүллээ.

Ийнхүү, Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний ээлжит хуралдаанд нийт 5 гишүүн оролцсоноос 2 гишүүн бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулж 10.5 хувьд хүргэх, 3 гишүүн 1 нэгж хувиар бууруулж 10 хувьд хүргэх санал гаргалаа. Төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээг өөрчлөх тухайд 5 гишүүнээс 2 гишүүн 1.5 хувиар бууруулж, 9 хувьд хүргэх, 3 гишүүн төгрөгийн ЗБН-ийг 2 хувиар бууруулж, 8.5 хувьд хүргэх саналыг дэмжив. Харин бодлогын хүүний коридорыг +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгож өөрчлөх саналыг МБХ-ны гишүүд 100 хувь дэмжиж бодлогын багц шийдвэр гаргав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх, банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд тогтоох болон бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгон өөрчлөх шийдвэр гаргалаа.